

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ГУРАВДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2024 оны 09 дүгээр сарын 30Улаанбаатар хот


НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.

2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 4697 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс судлагдаж байгаа 184, хуулийн хугацаанд 4507, хугацаа хэтрүүлэн 6 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 06 хоног 07 цаг 20 минут байна.

Засаг даргын Тамгын газарт 806 өргөдөл, гомдол ирүүлснээс судлагдаж байгаа 31, хуулийн хугацаанд 775 өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 08 хоног 12 цаг 35 минут байна.

ТӨРЛӨӨР АНГИЛЖ ҮЗВЭЛ:



Засаг даргын Тамгын Газар


НЭГЖҮҮД	ШИЙДВЭРЛЭСЭН						Шийдвэрлэлтийн дундаж хугацаа		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрсэн		Нийт					
	2023 IX/25	2024 IX/25	2023 IX/25	2024 IX/25	2023 IX/25	2024 IX/25	2023 IX/25	2024 IX/25	2023 IX/25	2024 IX/25
Удирдлага	10	0	0	0	1	0	04х17ц 27м		6	8
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	102	42	1	0	99	43	08х09ц 16м	09х12 ц 44м	11	10

Санхүү, төрийн сангийн хэлтэс	5	10	0	0	2	10	09х13ц 53м	05х07ц 09м	0	0
Нийгмийн хөгжлийн хэлтэс	15	21	0	0	40	21	13х08ц 51м	07х13ц 32м	1	0
Төлөвлөлт гүйцэтгэлийн удирлагын хэлтэс	39	52	0	0	80	54	07х20ц 22м	10х15ц 37м	2	1
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	284	346	0	0	116	359	08х05ц 46м	08х17ц 19м	16	3
Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	110	226	0	0	121	233	09х05ц 32м	09х09ц 00м	2	0
Цэргийн штаб	54	53	0	0	54	53	01х00ц 29м	00х07ц 56м	1	0
Хууль, эрх зүйн хэлтэс	9	24	0	0	10	27	07х04ц 18м	11х20ц 40м	3	3
Аж, ахуй, өмчийн хэлтэс	1	0	0	0	1	0	00х00ц 00м		0	0
Хэвлэл, мэдээллийн тасаг	3	0	0	0	3	0	00х21ц 09м		0	0
НИЙТ ДҮН	632	775	1	0	674	806	07х11ц 49м	08х12ц 35м	42	25
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ИНДЕКС									0,827	

ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД ГАРГАСАН ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ, БАЙГУУЛЛАГААР:

Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Байгууллагаар	Зөрчлийн тоо
Хангалтгүй шийдвэрлэсэн	5	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	5
Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	102	Засаг даргын Тамгын газар	25
Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	97	Харьяа хэлтэс, алба, тасаг	200
Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	163	Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	41
Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	8	Хороод	59
Холбогдох файл хавсаргаагүй	0	Эмнэлэг	45
НИЙТ	375	Сургууль, цэцэрлэг	0
		Дүүргийн хэмжээнд/нийт/	375

Зөрчлийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



ХАМГИЙН ИХ ГОМДОЛ ИРСЭН ХЭЛТЭС

1. Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс – 209 буюу 47,1 %
2. Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс – 164 буюу 36,9%
3. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс – 31 буюу 6,9%

ГОМДЛЫН ТЭРГҮҮЛЭХ АГУУЛГА

1. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны тухай – 54 буюу 12,19%
2. Орон сууцны 1-р давхарт байрлах үйлчилгээний газруудын тухай – 49 буюу 11,06 %
3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай – 47 буюу 10,61 %

ХОЁР. ИРГЭДЭЭС НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ГОМДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

1. Орон сууцны 1 давхарт байрлах үйлчилгээний газруудын тухай.

Орон сууцны нэгдүгээр давхарт иргэд оршин суугчдын эрх ашгийг зөрчин агааржуулалтын системийг стандартын бус байршуулж, явган зорчигч зорчих хэсэг буюу орц, гарцан дээр агааржуулалтын хоолойг гаргаж, түүнээс гарсан уур нь мөстөн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэнд сөргөөр нөлөөлж, улмаар байрны хийц эдлэлд өөрчлөлт орох, цаашид хөгцөрч, мөөгөнцөртөх эрсдэлтэй байгаа талаар иргэд, оршин суугчид, СӨХ-оос ирсэн гомдлыг эцэслэн шийдвэрлэх талаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хотын стандарт хяналтын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийтийн тээврийн газар, Нийслэлийн хяналт, шалгалтын газар, Нийслэлийн мал эмнэлэгийн газруудад холбогдох арга хэмжээ авч хамтран ажиллах талаар 8 удаагийн албан бичиг явуулж, арга хэмжээ тооцуулан ажилллаж байна.



2. Түргэн үйлчилгээний цэг, ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааны талаар

Дүүргийн Засаг даргын 2024 оны “Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай” А/27 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбай, автобусны буудалд явган хүний болон хөгжлийн бэрхшээлтэй хүний зам хааж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчимд зөвшөөрөлгүй байршуулсан 25 түргэн үйлчилгээний цэгийг дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлж ажилласан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны “Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт ил задгай, зөвшөөрөлгүй, худалдаа, үйлчилгээ явуулж буй иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” удирдамжаар Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мал эмнэлгийн тасаг, хороодтой хамтарсан ажлын хэсэг 6 удаагийн хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилган, 2 иргэнд тус бүр 20 нэгжийн



торгуулийн арга хэмжээ авч, мал эмнэлгийн ариун цэврийн магадлан шинжилгээний дээж авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулан, зөвлөн тусалж ажилласан.

Зайсан Туул гол дагуу стандарт шаардлага хангахгүй, өнгө үзэмжгүй нийт 17 байгууламжийг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж ажилласан.


Цаашид Туул гол дагуу үйлчилгээ явуулахгүй байх чиглэлээр Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, дүүрэг дэх Замын цагдаагийн газартай хамтран санал боловсруулан ажиллаж байна.



3. Хог хаягдал шатаах, орчны эвгүй үнэр, бохирдол, хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн талаар

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/125, А/225 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг дүүргийн мал эмнэлгийн тасаг, Тохижилт үйлчилгээний төвтэй хамтран зохион байгуулж, 3389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 23000м2 талбай бүхий хашаа хороо, худаг уст цэг, малын бэлчээр, хогын цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийж, ажилласан.

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо Зайсангийн эцсийн автобусны буудал орчим ариун цэврийн байгууламж байхгүй, гадуур дотуур бие засаад байна гэх гомдлын дагуу тус хороонд үйл ажиллагаа явуулж буй “Премиум нэксус” ХК-ийн Си-Юу” сүлжээ дэлгүүрийн менежертэй уулзаж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/861 дугаар “Хамтран ажиллах тухай” албан бичгийг өгч, иргэд үйлчлүүлэгчдэд ариун цэврийн өрөөгөөр тасралтгүй хэвийн үйлчлэх талаар чиглэл өгсөн.



Тухайн байгууллагаас ариун цэврийн өрөөгөөр үйлчлэхэд татгалзах асуудал байхгүй. Цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах талаар хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар зөвшилцсөн болно.



4. Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/125 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт орчны бохирдлыг бууруулах хаврын их цэвэрлэгээний аяныг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл зохион байгуулж ажилласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт хуримтлагдсан хур хог, малын өтөг бууц, сэг зэмийг ариутгаж, халдваргүйжүүлэн ачиж тээвэрлэх ажлыг дүүргийн мал эмнэлгийн 3 байгууллага, дүүргийн мал эмнэлгийн тасаг, “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлсэн.

Тус ажлын хүрээнд 8, 10, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хорогдсон нийт 3389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 12,000 м.кв талбай, 11,000 м.кв талбай бүхий хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг дүүргийн мал эмнэлгийн тасгийн хяналтан дор “Ганган буга” ХХК, “Туда” ХХК, “Гүнд тэрэм” ХХК-иуд хийж гүйцэтгэсэн.

Зураг . Малын сэг зэмийг ариутгаж, халдваргүйжүүлэх ажлын явц



Дүүргийн нутаг дэвсгэрт 23 байршилд үүссэн 5258.14 тонн үүсмэл болон хур хог хаягдал,





ариутгаж халдваргүйжүүлсэн малыг сэг зэм, өтөг бууцыг “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ нь хог тээврийн 13 хово автомашин, 2 автоковшоор нийт 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр цэвэрлэж, цуглуулан 264 рейсээр Морингийн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажилласан. Зураг . Хур болон үүсмэл хог хаягдал, малын өтөг бууц, сэг зэмийг цуглуулж, тээвэрлэх яв



Дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 21 дүгээр хурлын шийдвэрийн дагуу дүүргийн 15 дугаар хорооны Ривер вилла хотхоны урд хэсэгт Дунд голд унасан гүүрийг татан гаргаж, голд хуримтлагдсан 8 тонн хог хаягдлыг цэвэрлэн орчны бохирдлыг бууруулж ажилласан. Тус ажлыг дүүргийн “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ-аар хийж гүйцэтгүүлсэн.

Зураг . Дунд голд унасан гүүрийг гаргаж, хог хаягдлыг цэвэрлэсэн байдал



5. Гудамж, зам талбайн тохижилтын чиглэлээр:

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 5, 24 дүгээр хороонд 2 цэцэрлэгийн тохижилт ашиглалтад орж, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1, 13, 14 дүгээр хороонд шинээр байгуулах 3 бичил цэцэрлэгийн тохижилтын ажил зураг төсөл боловсруулах, дүүргийн төсвийн хөрөнгөөр 22 дугаар хороонд хэрэгжих цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил худалдан авах ажиллагааны шатанд тус тус хэрэгжиж байна. Үүнд:

- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 24 дүгээр хорооны Вива сити хорооллын ард Туул гол дагуу тоглоомын талбай, спорт талбай бүхий цэцэрлэгийн тохижилтын ажил хэрэгжиж, ашиглалтад орсон.

- Улсын төсвийн хөрөнгөөр 5 дугаар хороонд 41 дүгээр сургуулийн баруун талд хэрэгжиж буй цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлын хүрээнд 700 м.кв авто зогсоол, 300 м.кв налууд эко хавтангийн хучилтын ажил, 130 м.кв талбайд явган хүний зам тавих ажил, 5х5 сагсан бөмбөгийн талбай, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажил дуусаж, ашиглалтад оруулах шатанд хэрэгжиж байна.

- Хан-Уул дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул гол дагуу эрсдэлтэй бүсээс 28 айл өрхийг нүүлгэн шилжүүлж, тус талбайд иргэд, олон нийтэд зориулсан тохижилт, ногоон байгууламжийн ажлыг хэрэгжүүлэхээр Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай 2023 онд санамж бичиг байгуулж, 2024 оны дүүргийн төсөвт 5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах 1.2 тэрбум төгрөгийг тусгасан. Тус ажил 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар дахин тендер зарлах шатанд хэрэгжиж байна.

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч 1 дүгээр хорооны Эрэл хотхоны 38, 43-р байрны ард, 13 дугаар хорооны 4 дүгээр хэсэг, 14 дүгээр хорооны 156-р бага сургууль, 300-р цэцэрлэгийн гадна 3 байршилд шинээр бичил цэцэрлэг байгуулахаар гүйцэтгэгч шалгарсан, зураг төсөл боловсруулахаар ажиллаж байна.

Зураг . 24 дүгээр хороо, Туул голын эрэг дагуух талбайг тохижуулсан хүүхдийн тоглоомын талбай



Хүүхдийн тоглоомын талбайн стандарт, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 10, 13, 14, 17, 19 дүгээр хорооны 21 байршилд тоглоомын талбайг засварлах судалгаа, ажлын тоо хэмжээг гаргаж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/203 дугаар захирамжаар Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулж, хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 12 тоглоомын талбайн ажил хэрэгжсэн.

Зураг. 17 дугаар хорооны 36 айлын тоглоомын талбайн засвар шинэчлэлтийн ажил



6. Явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд

Явган хүний замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 2024 онд дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2,650.4 сая төгрөгийн хөрөнгөөр 22508.1 м.кв талбайд явган хүний замын ажил хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар гүйцэтгэлийн шатанд 4, худалдан авах ажиллагааны шатанд 2 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжиж байна. Үүнд:

Гүйцэтгэлийн шатанд хэрэгжиж буй төсөл арга хэмжээ:

1. Явган зам, талбайн засвар, шинэчлэлтийн ажил /23, 24-р хороо/
2. Явган хүний зам талбайн засвар, шинэчлэлт /11, 19, 20-р хороо/
3. Явган зам талбайн тохижилт /1,3, 15-р хороо/
4. Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, тохижилтын ажил (9, 16-р хороо, гэр хорооллын нарийн гудамжинд явган хүний зам тавих)

Худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж буй төсөл арга хэмжээ:

1. Явган хүний зам талбайн засвар, шинэчлэлт /2, 6, 17, 20-р хороо
2. Наадамчдын замаас Гарден сити хотхон, Арцат 2 хотхон хүртэл явган замын ажил (23 дугаар хороо)

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/291 дүгээр захирамжийн дагуу 145.4 сая төгрөгийн хөрөнгөөр Номун виллаж хотхон, Могол таун хотхонд шинээр явган хүний зам тавих, 1, 2, 3, 6, 18 дугаар хороонд эвдрэлтэй 418 м.кв явган хүний замыг нөхөж, засварлах ажил 50 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч дүүргийн 3 дугаар хороонд Ажилчны гудамжны явган хүний замыг өргөтгөж шинэчлэх (3870 м.кв) ажил гүйцэтгэгч шалгарсан, зураг төсөл боловсруулах шатанд хэрэгжиж байна.

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/169 дүгээр захирамжийн дагуу Хан-Уул зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 20 дугаар хороонд Туул голын эко зурвасаас буух шат, налуу зам (10.5*2 метр), 388 м.кв талбайд явган болон дугуйн замыг асфальтаар хучсан.

Зураг . 20 дугаар хороо, Туул голын эко зурвасаас буух шат, налуу зам, явган болон дугуйн замыг асфальтаар хучсан




Дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 23 дугаар хороонд Наадамчдын замаас Гарден сити 2 хороолол хүртэлх авто зам дагуух 1125 метр явган хүний зам, дугуйн замын тохижилтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй буюу өнгөлгөө будгийн ажлаас бусад ажлууд бүрэн хийгдсэн.

7. Гэрэлтүүлгийн чиглэлээр:

ДТХО, ДОНХС-ийн 5,890.0 сая төгрөгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орон сууц хороолол, гэр хороолол, авто зам дагуу нийт 1870 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах 6 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна.

- Ажлын явц гүйцэтгэлээр авч үзвэл 2024 оны 06 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар: Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил гүйцэтгэгч нь “РЗА” ХХК ажлын явц 60 хувь,
- Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажил гүйцэтгэгч нь “Эрчим өгий” ХХК ажлын явц 50 хувь,
- Авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр гэрэлтүүлэг хийх ажил (10, 12, 13 дугаар хороо) гүйцэтгэгч нь “Ингүүмэл эрчим” ХХК ажлын явц зураг төсөл боловсруулах шатандаа,

- Авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр гэрэлтүүлэг хийх ажил (14, 21 дүгээр хороо) гүйцэтгэгч нь “Өндрийн удам” ХХК ажлын явц зураг төсөл боловсруулах шатандаа,
- Наадамчдын авто замаас Нүхт чиглэлийн авто замын гэрэлтүүлгийн ажил (23 дугаар хороо) гүйцэтгэгч нь “Ингүүмэл эрчим” ХХК ажлын явц 80 хувь,
- Нийтийн эзэмшлийн зам талбайд гэрэлтүүлэг хийх (13 дугаар хороо) гүйцэтгэгч “Холбоотрейд” ХХК ажлын явц 80 хувьтай байна.
- Зураг . Хан-Уул дүүрэг, шинээр гэрэлтүүлэг суурилуулах ажлын явц




Дүүргийн хэмжээнд орон сууц хороолол, гэр хорооллын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 7113, төв зам дагуу 4252, нийт 11365 гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээг 3 байгууллагад хариуцуулан хяналт тавьж ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/59 дугаартай захирамжаар ажлын хэсэг байгуулж, сард 2 удаагийг давтамжтай, гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж ажиллаж байна. Хяналт шалгалтаар илэрсэн гэрэлтүүлгийн гэмтлээс орон сууц, гэр хороололд нийт 601 ширхэг шатсан гэрлийг шинээр засварлаж, 13 ширхэг хазайж далийсан шонг засаж, 714 метр агаарын сиб кабелиг шинээр татаж, 31 ширхэг гэрэлтүүлгийн самбарт засвар хийсэн.

Төв зам дагуу нийт 354 ширхэг шатсан гэрлийг шинээр засварлаж, 27 ширхэг хазайж далийсан шонг засаж, 1024 метр агаарын сиб кабелиг шинээр татаж, 45 ширхэг гэрэлтүүлгийн самбарт засвар хийсэн.

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 59, Наадамчдын зам дагуу 132 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, ил гарсан 489 метр кабелийг цэгцэлж булж, орчны аюулгүй байдлыг хангасан. Гэрэлтүүлгийн асалт 98,7 хувьтай байна.

Зураг. Хан-Уул дүүрэг, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний ажлын явц



8. Камержуулалтын чиглэлээр:

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023-2024 онд хэрэгжих буй камержуулалтын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажлын хүрээнд 9, 10, 16, 21-р хороодод 314 ширхэг камер суурилуулагдах бөгөөд зураг төсөв боловсруулагдах шатанд, "Камерын хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар хийх" төсөл, арга хэмжээний хүрээнд серверийн өрөөний тоноглол суурилуулалтын ажил хийгдэж хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 80%, "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт" төсөл арга хэмжээний хүрээнд 12, 13, 14, 16, 21-р хороодод тусгай зориулалтын 10 ширхэг камер суурилуулж, туршилт, тохируулга хийгдэж байна.

Зураг. Шинээр камер суурилуулах ажил



9 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:

Хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгаж буй сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудыг ангилсан хуванцраа тушаах, гэрээ байгуулах чиглэлээр "Ти Эм Эл" ХХК дахин боловсруулах үйлдвэртэй хамтарч ажиллаж дүүргийн хэмжээнд 234 байгууллага, СӨХ гэрээ байгуулж, хуванцар хаягдлаа нийлүүлж, дахин боловсруулж байна. Эко хотын тээвэр ААТҮГ нь 7 хоног бүрийн Пүрэв гарагт тогтмол 1 удаа 1, 2, 20, 23 дугаар хороодын нийт 8 цэгээс 7 удаагийн рейсээр 18,8 тонн хуванцар, лааз, цаасан хайрцаг, гялгар уутыг тээвэрлэсэн.

Хот байгуулалт, хотын стандартын хяналтын газартай байгууласан хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт сууц өмчлөгчдийн холбоодын удирдлага, ажилтнуудад хог хаягдлын ангилан ялгалтын чиглэлээрх хотын стандартын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж, 110 сууц өмчлөгчдийн холбоодын 160 хүн хамрагдсан.

Зураг . Ангилсан хог хаягдал тээвэрлэх явц



Дүүргийн төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжсэн XCMG маркийн задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 7 ширхэг хогны автомашиныг 2024 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хог тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн.

Зураг. Хог тээврийн задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 7 ширхэг хогны автомашиныг хог тээврийн байгууллагуудад хүлээлгэн өгөх үйл ажиллагаа



10 Хог цуглуулалт, тээвэрлэлт:

Дүүргийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хог тээврийн 4 байгууллагын цуглуулж, тээвэрлэсэн хог хаягдлын тоон мэдээлэл

Байгууллага	Рейс	Тээвэрлэсэн хог, тн	Хариуцсан хороо
“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	17,655	75,451	9, 10, 12, 13, 14, 16, 21, 25
“Хан-Уул Агро” ОНӨААТҮГ			11, 15, 17, 18, 22
“Хан-Эко тээвэр” ААТҮГ			4, 5, 6, 7, 8, 24
“Эко хотын тээвэр” ААТҮГ			1, 2, 3, 19, 20, 23
Нийт	17,655	75,451	25 хороо

11 Хөрс, орчны бохирдлыг бууруулах бүх нийтийн их цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийн чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/58 дугаар захирамжийн дагуу "Хоггүй Хан-Уул 2024" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 6 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 4795 аж ахуй нэгж байгууллага, 312 сууц өмчлөгчдийн холбоодын 4,881 хүн оролцож, 4,388,561 м.кв талбайгаас 891,3 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Зураг. Бүх нийтийн их цэвэрлэгээний явц



Дүүргийн нутаг дэвсгэрт 23 байршилд үүссэн 5258.14 тонн үүсмэл болон хур хог хаягдал, ариутгаж халдваргүйжүүлсэн малыг сэг зэм, өтөг бууцыг “Тохижилт үйлчилгээний төв”

ОНӨААТҮГ нь хог тээврийн 13 хово автомашин, 2 автоковшоор нийт 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр цэвэрлэж, цуглуулан 264 рейсээр Морингийн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажилласан.

12 Нийтийн эзэмшлийн зам талбайн, цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Чиг үүрэг шилжүүлэх тухай” 2023 оны А/1461 дүгээр захирамжаар хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжиж ирсэнээр нийт 4,225,209 м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээг 14 байгууллагад хариуцуулан, ажлын явц, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/162 дугаар захирамжийн дагуу “Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон” ТББ-тай гэрээ байгуулан дүүргийн нийтийн эзэмшлийн нийт зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд хөндлөнгийн хяналтыг гүйцэтгүүлж байна.



13. Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай холбоотой.

Эмнэлэгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмжийг сайжруулах чиглэлээр амбулаторийг шинээр зохион байгуулан 2024 оны 03 дугаар сарын 16-аас эхлэн дүрс оношилгоо / хэвлийн эхо/, сэргээн засах, уламжлалт эмчилгээ, дотор, зүрх судас, мэдрэл, өдрийн эмчилгээний нийт 6 үзлэг, тусламж үйлчилгээний өрөөг шинээр тохижуулан, 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлж эхэлсэн.

Хан-Уул Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхээр ирж байгаа үйлчлүүлэгчдийг хүлээн авч, зөв чиглүүлэн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай, аюулгүй үйлчлэх боломжоор хангах зорилгоор төвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/07 дугаар тушаалаар "АЖИЛТАН БҮР ХӨТӨЧ" сэдэвт аяныг 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулж, энэхүү аянд тасаг нэгжийн бүх эмч, ажилчдыг 8 баг болгон үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ хийсний дагуу “Сэтгэц, сэргээн засах тасгийг 10 ортойгоор нээн ажиллуулж байна.

Эрүүл мэндийн төвд сэтгэц, аддиктологийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор сэтгэцийн нийгмийн сэргээн засах тасгийг 10 ортойгоор 2024 оны 01 дүгээр сараас нээж, архины хамааралтай, донтох эмгэгтэй болон сэтгэцийн тулгамдсан асуудалтай иргэдэд донтох эмгэгийн тусламж үйлчилгээг үзүүлэх, мөн иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн боловсролын түвшинг сургалт, нөлөөллийн аргаар нэмэгдүүлэх ажлуудыг хийж байна.

Тус тасагт:

- Сэтгэц, аддиктологийн эмч 2
- Сэтгэл зүйч 1

- Сувилагч 1
- Асрагч 1 шинээр авч ажиллуулаад байна.

2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар сэтгэцийн нийгмийн сэргээн засах тасагт:

- Хэвтэн эмчлүүлсэн иргэд 145
- Өдрийн эмчилгээнд хамрагдсан 131
- Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө авсан 37
- Сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө авсан 145 үйлчлүүлэгч байна.

Тусламж үйлчилгээ авсан иргэдийн 20% нь архины шалтгаант сэтгэцийн ба төрх үйлийн эмгэгтэй, 65% нь неврозын бусад эмгэгтэй, 15% нь оюуны хомсдолтой үйлчлүүлэгч эзэлж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйлчлүүлж байгаа иргэдийн цаг товлал, цаг авах үйлчилгээтэй холбоотой “Үйлчлүүлэгчийг дэмжих алба” байгуулж, Call care үйлчилгээ 72012222 дугаарын утсыг ажиллуулж, иргэдтэй утсаар нь холбогдож нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх цаг авч өгөх үйлчилгээг үзүүлж байна. Хан-Уул эрүүл мэндийн төвд хэрэгжиж байгаа “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч нараас илгээсэн артерийн даралт ихдэх өвчин, чихрийн шижин, дислипидеми, сүрьеэ өвчтэй иргэдийг E'mongolia болон цахим бүртгэлээс цаг авахгүйгээр дэмжих албаны 2 эмч шууд цаг өгч зүрх судас, мэдрэл, дотоод шүүрэл, сүрьеэгийн эмч нарт үзүүлж байна.

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Хан Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн даргын А/01 тоот тушаалаар 266 ажилтантай байсан. 2023 оны 4 сарын 27 ны өдрийн Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн даргын А/35 тоот тушаалаар 295 эмч эмнэлгийн ажилтантай болж орон тоог нэмсэн.

Тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах зорилгоор:

1. Яаралтай тусламжийн тасагт 4 ш амьсгалын аппарат, 5 ш хяналтын монитор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, отсос-3ш, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, дефибрилятор, хүчилтөрөгчийн зөөврийн баллон, муляж тус тус ашиглагдаж байна. Одоогоор гэмтэлтэй тоног төхөөрөмж байхгүй.

2. 2024 онд шинээр хяналтын монитор-1ш, муляж-2ш ширхэг нийлүүлэгдсэн. 3ш амьсгалын аппаратны сенсор сольж, 1ш амьсгалын аппаратны батерей сольж хэвийн ажиллагаанд оруулсан. Тоног төхөрөөмжийн бэлэн байдал, цаг ашиглалт дээр 4 удаа үнэлгээ хийсэн.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах чиглэлээр:

1. Био салбарт: Амбулаторийн үйл ажиллагааг шинээр зохион байгуулан 2024 оны 03 дугаар сарын 16-аас эхлэн дүрс оношилгоо / хэвлийн эхо/, сэргээн засах, уламжлалт эмчилгээ, дотор, зүрх судас, мэдрэл, өдрийн эмчилгээний нийт 6 үзлэг, тусламж үйлчилгээний өрөөг шинээр тохижуулан, 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлж эхэлсэн.

2. Хавдар хөнгөвчлөхийн тасгийг дотрын тасгийн хэсэгт тусад нь 10 ортойгоор зохион байгуулж, иж бүрэн засвар тохижилтийн ажлыг нийслэлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж хүний нөөц тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн.

3. Хэвлийн дурангийн мэс заслын тоног төхөөрөмжийг Дүүргийн засаг даргын санхүүжилтээр шийдвэрлэн 2024 оны 05.07-ны өдөр Shenda брэндийн иж бүрэн дуранг ариутгалын төрөөхөмжийн хамт хүлээн авч үйл ажиллагааг эхлүүлээд байна.

4. Эко амбулаторит Эрэгтэйчүүдийн кабинетийг шинээр байгуулан ажиллаж мэдээллийн самбар, эхо аппаратаар хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмчилгээ оношлогооны хүртээмжийг сайжруулсан.

5. Салбар амбулаторийн болон экоамбулаторийн хэсэгт сэргээн засах уламжлалт кабинетийн тоог нэмэгдүүлэн ажилласан. Эко амбулаторийн тасагт 1820 хүнд 6335 удаа үйлчилгээ үзүүлсэн. 9005 удаа физик эмчилгээ хийсэн. 1513-3041 хүнд 6735 удаа хөдөлгөөн засал хийсэн

6. ГССҮТөвтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж хамтын ажиллагааны дагуу Монгол улсын хүний гавьяат эмч Ө.Өлзийбаатар эмч нэг сарын турш ажиллаж нийт 500 гаруй иргэнд гэмтэл согогын зөвлөх эмчийн үзлэг хийж эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд Өвдөгний үений артроз сэдэвт сургалт хийсэн. Сургалтад нийт 17 хүн хамрагдсан. Хүүхдийн гэмтэл Согог судлалын их эмч Болдбаатар 05 сард сарын хугацаанд ажиллаж амбулаторийн үзлэг оношилгоо хийж нийтдээ 200 үйлчлүүлэгч үзэж “ХҮҮХЭД АЮУЛГҮЙ ОРЧИН” сэдэвт сургалтыг хийж 23 хүн хамрагдсан.

ГУРАВ. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх 5 арга хэмжээтэй төлөвлөгөө боловсруулж 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна.

2. Нийслэлийн Засаг даргын А/91 дүгээр захирамжийн хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах” А/19 дүгээр тушаал батлагдаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах, гомдол гарахад нөлөөлж буй хүчин зүйлийн үнэлгээг сүүлийн 3 жилийн мэдээлэлд үндэслэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, түүний дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээний саналыг хэлтсүүдээс авч дүгнэлтийг нэгтгэн ажилласан.

3. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад зөрчил гаргасан Засаг даргын дэргэдэх байгууллагуудад Засаг даргын Тамгын газрын даргын 2024.01.10-ны өдрийн 03/51, 03/52, 03/53, 03/54, 03/55, 2024.02.06-ны өдрийн 03/221, 2024 оны 04.25-ны өдрийн 03/765, 03/766, 03/767, 03/768, 03/769, 03/770, 03/771, 03/772, 2024 оны 05.30-ны өдрийн 03/1067, 03/1068, 03/1069 2024 оны 09 дүгээр сарын 12-ны 03/1843, 03/1844, 03/1845, 03/1847, 03/1851 тоот албан бичгүүдээр тус тус чиглэл хүргүүлэн ажилласан.

4. 2024 оны 09 сарын 26, 27-ны өдрүүдэд Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороодын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

5. Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад болон Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааг багасгах, зөрчлийг бууруулах зорилготой “Ажиллангаа шагнуулъя” уралдааныг үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.МӨНХГЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АЖИЛТАН

Г.ЭРДЭНЭСУГАР